



Л.Ариунжаргал
МУБИС-ийн БоСС-ийн Боловсролын Судалгаа
Аргазүйн тэнхимийн багш, доктор (Ph.D)



Б.Ононтуул
МУБИС-ийн БоСС-ийн Боловсролын Судалгаа
Аргазүйн тэнхимийн багш, магистр

ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН МАТЕРИАЛЛАГ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

(Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн¹ хүрээнд хийсэн судалгаа)

Abstract: The effects of learning environment and resources such as classroom, library and all services excluding everyday classroom learning at Mongolian State University of Education (MSUE) and students' learning activities were examined with an aim to answer the question 'Are the services provided by MSUE for students adequate?'. One of the aims of MSUE is that to educate every student while providing them with good services and to develop every student. We tried to investigate real problems related to the learning environment.

Key words: schools, learning environment, library, classrooms, breaks, lunch

Судалгааны зорилго

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн зорилго бол "Хувь хүний сонирхол, нийгмийн хэрэгцээ, олон улсын чиг хандлагад нийцсэн багш болон бусад боловсрол эзэмших, судлах, хөгжүүлэх иргэдэд нээлттэй, чанартай үйлчилнэ"¹ юм. Ойрын жилүүдэд оюутанд үзүүлж буй хамгийн харагдахуйц, сайшаалтай арга хэмжээ бол элсэлтийн шалгалтад өндөр оноо аван элсэн орж буй оюутанд үзүүлэх төлбөрийн хөнгөлөлт, багшлах дадлагын тэтгэлэг зэрэг олон төрлийн арга хэмжээ бөгөөд уг арга хэмжээнд оюутнууд талархалтай хандаж байна². Гэвч эдгээр нь МУБИС-ийн хэмжээнд суралцаж буй бүх оюутанд хүрч буй үйлчилгээ болж хараахан чадаагүй байгаа нь ч оюутнуудтай ярилцах, хамтран ажиллах явцад тодорхой болсон.

Эндээс бүх оюутны хэмжээнд үзүүлж

буй өдөр тутмын үйлчилгээ нь материаллаг орчин³ талаасаа оюутан нэг бүрийн хэрэгцээг хангаж байна уу гэдэгт анхаарлаа хандуулах хэрэгцээ гарах нь зайлшгүй юм. Уг судалгаа нь дээрх асуултын хариуг олохын тулд МУБИС-ийн сургалтын орчин, материаллаг нөөц (үүнд сургалтын анги танхим, номын сан⁴ болон оюутны өдөр тутам хичээлээс гадуур үйлчилгээ авч буй орчин хамаарна) нь оюутан бүхний сурах үйл явцад хэрхэн нөлөөлж буй талаар судлан үзэж, шинжилгээ хийх зорилготой бөгөөд 2 үе шаттай хийсэн судалгааны 2-р үе⁵ буюу үндсэн судалгаа юм. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх багш мэргэжилтэн бэлтгэж⁶ буй сургуулийн хувьд оюутан нэг бүрийг хөгжүүлэн, чанартай үйлчилгээ үзүүлэх нь уг сургуулийн зорилго байх учиртай билээ. Нөгөө талаар их, дээд сургуульд (магадлан итгэмжлэл) болон багш нарын ажлыг үнэлэхэд тавигддаг шаардлага нь оюутан суралцагчдын суралцах орчин, нөхцөл боломжтой нийцэхгүй байгаа нь уг

³ Их дээд сургуулийн сургалтын материаллаг орчны тухай "Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих нийтлэг шаардлага", "Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэхэд тавих урьдчилсан шаардлагууд" байх ба үүнд үндэслэн их дээд сургуулиуд "Мастер төлөвлөгөө"-гөө гаргана. Уг судалгааны хүрээнд "МУБИС-ийг 2007-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-г судалсан болно. Уг мастер төлөвлөгөөний 2-3-т заасан Сургалт, түүний орчныг хөгжүүлэх хэсгийн заалтаас МУБИС-ийн сургалтын орчны талаар баримтлах бодлогын талаар харж болно.

⁴ Их дээд сургуулийн номын сангууд нь Стандартчлал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2007 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага /MNS 5742: 2007/-д тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах ёстой.

⁵ Тандалт судалгааг 2013 оны 11 сард МУБИС-ийн салбар 2 сургуулийн (ДУТС, МоСС) 114 оюутнаас асуулгын аргаар авсан болно.

⁶ МУБИС веб хуудас /Сүүлийн хандалт: 2014-03-15/

¹ МУБИС-ийн зорилго. МУБИС веб хуудас /Сүүлийн хандалт: 2014-03-15/

² Тандалт судалгааны өмнөх оюутантай хийсэн ярилцлага судалгаа. 2013 он 10 сар.

судалгаа хийх нэг үндэслэл болж байгаа юм.

Судлагдсан байдал

МУБИС-ийн хэмжээнд сургалтын орчин болон оюутанд үзүүлэх үйлчилгээний талаар “... чанартай үйлчилнэ” гэсэн зорилго тавьсан байгаа боловч сургуулийн сургалтын орчин, материаллаг нөөцийн талаарх судалгаа явуулан түүний үр дүнг сургалтад нэвтрүүлсэн тухай судалгааны ажлыг хийгээгүй, эсвэл судалгаа явуулсан боловч үр дүнг нийтэд мэдээлээгүй байж болох юм. Иймээс уг судалгааны асуултуудыг өөрсдийн хийсэн тандалт буюу 1-р үед хийсэн судалгаанд үндэслэн боловсруулалт хийж, МУБИС-ийн салбар 12 сургуулийн 2-р курсийн оюутнуудаас асуулгын аргаар авсан болно.

Судалгааны үндсэн хэсэг

А) Асуулга судалгааны талаар

Судалгаанд МУБИС-ийн 12 салбар сургуулийн 335 оюутан хамрагдсан болно. Уг судалгаа нь 2 үе шаттай судалгааны үндсэн судалгаа учир МУБИС-ийн бүх салбар сургуулийн сургалтын орчны талаар судалж үзэхийн тулд МУБИС-ийн Архангай аймаг дахь салбараас бусад бүх сургуулийн төлөөлөл болгож нэг салбар сургуулиас 2-р курсийн 20-25 оюутныг түүвэрлэн хамруулсан болно.

В) Судалгаанд оролцогчдын тухай:

Судалгаанд нийт 335 оюутан оролцсон бөгөөд үүнээс хүйсийн харьцааг авч үзвэл эмэгтэй 265, эрэгтэй 56, хариулаагүй 14 оюутан байсан бол дундаж нас 19,6 байна. Үүнээс 105 оюутан гэртээ, 69 оюутан дотуур байранд, 70 оюутан айлд, 72 оюутан байр түрээсэлж, бусад 4, хариулаагүй 15 байна.

Уг судалгааг

А. МУБИС-ийн анги танхим болон номын сан, бусад үйлчилгээний талаар,

Б. Үдийн хоол ба завсарлагааны цагийн тухай,

В. Үндсэн мэдээлэл гэсэн 3-н хэсэгтэй явуулсан болно.

С. Судалгааны боловсруулалт


С-1. МУБИС-ийн анги танхим болон номын сан, бусад үйлчилгээний талаар

Уг судалгааны нэгдүгээр үндсэн хэсэг А. МУБИС-ийн анги танхим болон номын сан, бусад үйлчилгээний талаар-т хичээлийн анги танхим, номын сангийн тухай 16 асуултаас бүрдсэн болно. Үүнээс сонирхолтой үр дүнгээс авч үзье. 1.Таны бодлоор МУБИС-ийн сургалтын материаллаг

орчин, нөхцөл нь оюутан таны сурах хэрэгцээг бүрэн хангасан гэж үзэж байна уу? 2.Анги танхимын тав тухтай орчин бүрдсэн эсэх? зэрэг асуултад хариулснаас үзэхэд оюутнууд МУБИС-ийн сургалтын орчин болон анги танхимын талаар 73.4% буюу 246 оюутан, 59.7% буюу 200 оюутан тодорхой хэмжээнд тийм гэсэн эерэг хариултыг сонгосон байна /График 1/.



Дараагийн асуултууд болох “Сургууль дээр хичээлээ ихэвчлэн хаана давтдаг вэ?”, “Хамтран хийх даалгавар, бие даалтыг хаана хийдэг вэ?” гэсэн асуултуудад оюутнууд ихэвчлэн “Номын сан”, “Коридорт” гэж хариулсан байна. Номын сан нь суралцагчдын суралцах хамгийн гол газар гэж үздэг ч үүнээс гадна оюутнуудын 22,1% нь коридорт хичээлээ хийж байгаа нь тэдний суралцах орчин нөхцөл, түүний хүртээмжийн асуудалтай шууд холбоотой юм /График 2/.



Бусад гэдэг хариултыг сонгосон оюутнуудын хувьд номын санд суудал байдаггүй учир гэртээ эсвэл өөр номын сан, хэн нэгнийдээ, гэртээ хийдэг гэж хариулсан байна. МУБИС-ийн төв номын сан, салбар сургуулиудын номын сангийн талаарх асуулт болох “МУБИС-ийн төв номын сангаар байнга үйлчлүүлдэг эсэх?”, “Таны бодлоор МУБИС-ийн төв номын сан хичээл хийхэд хэр таатай орчин бэ? асуултын хариулт (16,4 % нь тийм, 33,4 % нь хааяа, бараг л үгүй 19,4%, үйлчлүүлж үзээгүй 29,6%) аас дүгнэхэд



ямар нэгэн байдлаар номын сангаар үйлчлүүлдэг болох нь тодорхой байгаа боловч, “Үйлчлүүлж үзээгүй” 29,6% байгаа нь оюутнууд зөвхөн салбар сургуулийн номын сангаар л үйлчлүүлэх ёстой гэдэг өрөөсгөл ойлголттой байдагтай холбоотой байх магадлалтай юм. Гэхдээ номын сангийн талаар үнэхээр таатай орчин 10,4%, тодорхой хэмжээнд таатай орчин 46,6%, хичээл хийхэд хүндрэлтэй байдаг 17,6%, таагүй орчин 2,1%, хариулаагүй 78 оюутан буюу 23,3% байснаас дүгнэхэд хариулаагүй 23,3%, Хичээл хийхэд хүндрэлтэй байдаг 17,6%-тай нийлүүлээд бодоход 40,9% нь номын сангийн талаар сөрөг буюу сэтгэл ханамжгүй байгаа нь харагдаж байна.

Эдгээр асуултын задаргаа болох “Таагүй” гэж хариулсан оюутнууд “Яагаад таагүй байдаг вэ” гэсэн асуултад “Олон оюутантай учир шуугиантай”, “Хүүхдүүд дэндүү их ярьдаг, дуу чимээ ихтэй, хангалттай том биш”, “Их жижигхэн учир суудал бараг олддоггүй”, “Номын санд багаар ажиллах даалгаврыг хийж болдоггүй”, “Номын санчид харьцаа муутай, соёлгүй”, “Харгалзагч эгч харьцаа муутай, ирж загнадаг”, “Номын хүрэлцээ муу” зэрэг хариултыг олон оюутан өгсөн байна.

Мөн салбар сургуулийн номын сангийн тухай асуултуудад “Номын сан маш жижиг, суудал хүрэлцдэггүй, номын хүрэлцээ муу, оюутнууд маш их ярьдаг” гэдэг хариултыг дийлэнх оюутан өгсөн байна. Мөн сургуулиудын онцлогоос хамаараад сургууль бүрийн номын сангийн тухай оюутнууд өөрсдийн бодлыг дараах байдлаар илэрхийлсэн нь харагдаж байна. Жишээ нь ДУТС⁷-ийн оюутнууд “Салбар сургууль номын сан байдаггүй, оёх болон зурах зэрэг даалгаврыг хийхэд бусад сургуулийн номын санд хийхээр загнаад хийлгэдэггүй” гэдэг хариулт маш олон давтамжтай өгсөн ба В байрны номын сангийн тухай “00 өрөөний хажууд учир муухай үнэртэй, Давчуу харанхуй, салбар сургуулийн номын санч эгч харьцаа муутай болохоор бараг очдоггүй, харанхуй гэрэлтүүлэг муу, жижигхэн номын хүрэлцээ муу, агааржуулалт муу учир толгой хурдан өвддөг” гэсэн хариулт олон байсан бол Гадаад хэлний сургуулийн номын сангийн хувьд “Подвальд байдаг, жижигхэн цонхтой, бүгчим, гэрэлтүүлэг муу, интернэт байхгүй учир заавал өөр газар хичээлээ хийх болдог, номын хүрэлцээ муу” зэрэг хариултыг олноор өгсөн нь анхаарал татаж байна.

Мөн бүрэлдэхүүний сургуулиудын номын сангийн тухай дээрх хариултуудыг олон давтамжтай өгсөн байгаагаас харахад, МУБИС-ийн салбар сургуулиудын номын сангийн

орчин оюутанд суралцах таатай нөхцөлийг бүрдүүлээгүй нь харагдаж байгаа бөгөөд багш бидний оюутнаас шаарддаг багаар хийх даалгаврыг хийх орчин МУБИС-ийн хэмжээнд хаана ч байхгүй байгаа нь ч уг судалгаагаар харагдсан юм. Мөн бусад сургуульд “Номын сан байдаггүй, ховор номын хүртээмж маш муу” байдаг талаар хариултуудыг өгсөн ба эдгээр оюутан дараах шалтгаануудаар бусад олон нийтийн болон их, дээд сургуулиудын номын санг ашигладаг тухайгаа бичсэн байна. Үүнд МУБИС-ийн номын сангаас Үйлчилгээ сайтай /34 оюутан/, Тохиллог /54 оюутан/, Номын хүртээмж ихтэй /90 оюутан/, Гэрт ойр /23 оюутан/, Гэрээр ном олгодог /28 оюутан/, Ховор номын фондтой /54 оюутан/, Амралтын өдөр үйлчлүүлэх боломжтой /47 оюутан/, Интернэт ашиглах боломжтой /36 оюутан/ зэрэг шалтгааныг бичсэн байсан ба үйлчлүүлдэг номын сангийн тухайд дараах номын сангууд ихэнх хувийг эзэлсэн байна. Төв номын сан, ШУТИС-ийн номын сан, 1-р хорооллын номын сан, Нацагдоржийн нэрэмжит номын сан, Хүүхдийн номын сан, Хүүхдийн ордны номын сан, Цамбагарав дахь номын сан, МУИС-ийн 2-р байрны номын сангаар үйлчлүүлдэг тухайгаа бичсэн байна. Мөн уг асуултын хариултад олдохгүй номыг “Найз нарынхаа сургуулиас авч хэрэглэдэг” гэсэн хариулт олон биш ч гарсан бөгөөд эндээс хичээлээ хийхийн тулд оюутнууд тодорхой хэмжээнд номын эрэл хайгуул хийдэг болох нь харагдаж байна. Түүнчлэн оюутны дотуур байрны номын сан ч хичээл хийхэд тийм ч таатай орчин биш болох нь уг судалгаагаар харагдсан юм.

Уг бүлгийн сүүлийн асуулт болох “Та хичээлгүй үед сургууль дээр ихэнх цагаа хаана өнгөрөөдөг вэ?” гэсэн асуултад 39,2% буюу 131 оюутан “Байх газар байдаггүй учир гэртээ харьдаг” гэсэн хариултыг өгснөөс харахад сургууль дээр оюутан хичээл хийх боломж, орчны асуудал ямар байгааг давхар харуулж байгаа бөгөөд “Коридорт” гэсэн хариултыг 16,8% буюу 56 оюутан сонгосон байгааг ч анзааралгүй өнгөрч болохгүй юм.

С-2. Үдийн хоол ба завсарлагааны цагийн тухай

Оюутнууд өдөрт дунджаар 2-3 пар буюу өдрийн 4 цаг орчмын хичээлтэй байдаг юм байна. Завсарлагааны цагаар ихэнх оюутан (69,9 % буюу 234 оюутан) “Дараагийн хичээл орох ангид очоод завсарлагааны цаг дуусдаг” гэсэн бол, “Хооллодог” гэсэн оюутан 12,8 % буюу 43 байсан бол цөөн оюутан “Хичээлээ давтдаг” гэх мэтчилэн хариулсан байна.

Мөн үдийн хоолоо иддэг эсэх талаар асуухад 42,1% нь иддэггүй, 46% нь завсарлагаагаар иддэг, 6,9% нь хичээл дээрээ иддэг гэж хариулсан байна. Үүнтэй хамааралтайгаар “Завсарлагааны минут хоол идэхэд хангалттай байдаг уу” гэсэн

⁷ Дүрслэх урлаг технологийн сургууль

асуултыг тавихад 83,3% буюу 276 оюутан “Үгүй” гэсэн хариултыг өгсөн байна.

Мөн “Иддэггүй” гэсэн хариултыг өгсөн оюутнууд дараах шалтгаануудыг бичсэн байна. Үүнд хамгийн их давтамжтай байсан хариулт бол “Завсарлагааны цагаар амждаггүй” гэсэн хариулт байсан ба үүндээ “Салбар сургууль цайны газар байхгүй”, “Хол байдаг”, “Санхүүгийн боломж байдаггүй” гэсэн асуудлуудыг бичсэн байсан, мөн “Салбар сургуулийн цайны газар жижиг учир дугаарлаад цайны цаг дуусдаг” гэсэн хариулт ч маш олон давтамжтай байлаа. Мөн “Хоол идээд орохоор хоцордог учир багшид загнуулдаг, багш нар оруулдаггүй”, “Өмнөх хичээл нь цагтаа завсарладаггүй учир хоол идэх боломж байдаггүй” гэх мэт багш биднээс шалтгаалах асуудлуудыг маш олон давтамжтай хөндсөн байлаа. Өмнө гарсан асуултуудын адил энэ бүлэг асуултаас ч бүрэлдэхүүн сургуулиудын онцлогийг харж болох юм. Жишээ нь “А байранд цайны газар байдаггүй”, “В байрны 7-р давхраас бууж байтал завсарлагааны цаг дуусдаг” гэх мэтчилэн бүрэлдэхүүн сургуулиудын асуудлуудыг шүүмжлэлтэйгээр дурдан гаргасан байгааг уг судалгаанаас харж болох юм.

Мөн үдийн хоол ба завсарлагааны цагийг зохицуулах шаардлага байна гэж 79,1% нь хариулсан юм. Уг оюутнуудаас “Үдийн хоолны ба завсарлагааны цагийг яаж зохицуулбал боломжтой гэж бодож байна вэ?” гэсэн асуултад хамгийн олон давтамжтай байсан хариулт нь “Үдийн цайны завсарлагатай болох” гэсэн хариулт байсан ба “30 минутын урт завсарлагатай болох”, “ШУТИС шиг урт завсарлагатай болох”, “Ямар ч байсан хоол идэх завсарлагатай болох”, “Салбар сургууль дотроо цайны газартай болох”, “Байгаа цайны газраа томсгох” зэргийг ч маш олон оюутан хөндөн бичсэн байлаа.

Судалгааны төгсгөлд “МУБИС-ийн сургалтын орчин болон уг судалгааны талаар ямар нэг санал хүсэлт, асуулт байвал бичнэ үү” гэсэн нээлттэй асуултыг оруулахад судалгаанд хамрагдсан оюутнууд маш үнэтэй саналуудыг бичсэн байна. Эдгээрээс жишээ дурдвал:

“Багаар ажиллах анги танхимтай болох”,

“Оюутны бие даах төвтэй болох”,

“Номын сангийн орчныг сайжруулах”,

“Номын сангийн номын хүртээмжийг нэмэгдүүлэх”

“Их завсарлагаатай болох”,

“Сургуулийн орчинд үнэгүй WIFI ашигладаг орчныг бий болгох”,

“Багш нарын оюутантай харьцах харьцааг анхаарах”,

“Ариун цэврийн өрөөг сайжруулах”,

“Цайны газрын хоолны чанарт анхаарах”,

“Хичээлгүй ангид чөлөөтэй сууж хичээлээ давтдаг боломжоор хангах”,

“Сургууль дээр 22 цаг хүртэл хичээл хийх боломжийг бүрдүүлэх”,

“Чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх заал танхимтай болох”,

“Компьютерын үйлчилгээний орой болтол ажилладаг танхимтай болох”,

“Багшийн сургууль биеийн тамирын заалтай болмоор байна”,

“Өлгүүрийн эгчийг солимоор байна”,

“Номын санч харьцааны соёлтой болох” зэрэг оюутнуудын хувьд тулгамдаж буй өөрчлөлтийг хүсэж буй асуудлуудыг материаллаг зүйлээс эхлэн тэр дор нь засаж болохуйц харьцааны асуудал хүртэл хөндөн гаргаж ирсэн байна. Мөн уг судалгаагаар дамжин эдгээр асуудлыг шийдэж өгөхийг ч хүссэн байлаа.

ДҮГНЭЛТ

Тус судалгааны үр дүн буюу судалгааны боловсруулалтаас МУБИС-ийн оюутанд үйлчилж буй үйлчилгээний талаар оюутнуудын санал, дүгнэлтүүд гарсан гэж үзэж байна. МУБИС-ийн зорилгод буй “...чанартай үйлчилнэ” гэсэн зорилтын хамгийн наад захын шаардлага болох Оюутнуудын сурах орчин, мөн оюутны хичээл хийх хамгийн тохиромжтой орчин болох номын сангийн тав тух, үдийн цайны цагийн зохицуулалтын байдал болон багш ажилчдын харьцааны асуудлаас эхлэн олон асуудлын өнөөгийн дүр төрхийг судалгааны дүнгээс харж болох юм. Уг судалгаагаар гарсан үр дүнг энэ хэвээр нь үлдээх бус бага ч гэсэн санаа аван ид өрнөж буй “Бүтцийн өөрчлөлт” буюу сургуулийн дотоод өөрчлөлтийг хийх үйл явцад тусган оюутнуудын сургалтын орчинд ч “Өөрчлөлт”-ийг хийгээсэй гэж хүсэж байна. Үгүй бол “...чанартай үйлчилнэ” гэсэн хоосон зорилготойгоор суралцах тухтай орчин бүрдээгүй, ном сурах бичгээр хангагдаагүй, хоосон гэдэстэй, хоол идэх боломжгүй, коридорт хичээл хийх оюутнуудаасаа сурлагын амжилт, сайн багш болохыг шаардсаар, хүссээр л байх уу?

Судалгааны хязгаарлагдмал байдал

Уг судалгаанд МУБИС-ийн салбар 12 сургуулийн 2-р курсийн оюутнууд оролцсон бөгөөд сургууль бүрийг төлөөлж 20-25 оюутан оролцуулсан учир нийт оюутныг хамруулаагүй учир судалгааны үр дүн нь МУБИС-ийн нийт оюутныг төлөөлөхгүй. Мөн судалгаанд бүрэлдэхүүн сургууль бүрээс төлөөлөл оролцуулахыг зорьсон бөгөөд судалгааны боловсруулалтыг харгалзан үзэж асуулгын аргаар судалсан болно. Мөн уг судалгааг цаашид бусад их, дээд сургуулийн оюутнуудын дунд явуулан МУБИС болоод бусад их, дээд сургуулийн сургалтын орчин, өнөөгийн



бодит байдалд харьцуулсан дүн шинжилгээ хийж, цаашид сургалтын орчныг сайжруулах боломжийг хайх нь зүйтэй юм.

Жич: Уг судалгаанд чин сэтгэлээсээ хандан үнэтэй саналаа нэмэрлэсэн МУБИС-ийн салбар сургуулиудын II курсийн оюутнууддаа баярлалаа.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Батхуяг. С. (2012). *Дээд боловсролын шинэчлэл*. Улаанбаатар
- Даваа, Ж., Г. Сарантуяа. (2013). *Дээд сургуулийн сургалтын технологи*. Улаанбаатар
- Оюунбилэг.Д (2007). *Монголын сургуулийн ба хүүхдийн номын сан*. Улаанбаатар
- Цэдэвсүрэн, Н. (2006). *Сурах сургах орчны онол аргазүйн үндэс. Судалгаа, туршилт, дүгнэлт*. Улаанбаатар
- Монгол Улсын Боловсролын Их Сургууль. (2003). *БоСС “Оюутны лавлагаа”* Улаанбаатар
- Монгол Улсын Боловсролын Их Сургууль. (2003). *МУБИС-д мөрдөх дүрэм журам*. Улаанбаатар
- Монгол Улсын Боловсролын Их Сургууль. (2011). *МУБИС-д мөрдөх дүрэм журам*. Улаанбаатар

<http://www.msue.edu.mn/>

<http://www.meds.gov.mn/>

